

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА СЭЛЭНГЭ
АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 11 дүгээр
сарын 12-ны өдөр

Сүхбаатар сум.

Тус хэлтэс нь Улсын бүртгэлийн байгууллагын бодлогын шинэчлэлийн хүрээнд хүрээнд Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ХЗДХЯ-ны сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2024-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний дагуу хэлтсийн үйл ажиллагааны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулах зорилгод тулгуурлан 10 зорилт, 42 арга хэмжээний биелэлтийг ханган дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Иргэний улсын бүртгэлд:

- ✓ Төрсний 1141
- ✓ Үрчилсний 27
- ✓ Овог, эцэг /эх/-ийн нэр, нэрээ өөрчилсний 44
- ✓ Эцэг/эх/ тогтоосны 67
- ✓ Гэрлэсний 257
- ✓ Гэрлэлт дуусгавар болсны 108
- ✓ Нас барсны 527
- ✓ Иргэний үнэмлэхийн 3647
- ✓ Шилжилт хөдөлгөөний 3318
- ✓ Гадаад паспортын 3992
- ✓ Регистрийн дугаар өөрчилсний 6
- ✓ Лавлагаа 10478 олгожээ.

Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэгт заасны дагуу засаг захиргааны нэгжийн харьяалал харгалзахгүйгээр:

- ✓ Төрсний 410
- ✓ Эцэг /эх/ тогтоосны 08
- ✓ Гэрлэсний 100
- ✓ Гэрлэлт дуусгавар болсны 38
- ✓ Нас барсны 88
- ✓ Иргэний үнэмлэхийн 720
- ✓ Гадаад паспортын 624
- ✓ Лавлагаа 5340 олгожээ.

Монгол улс-Оросын Холбооны Улсын хилийг цааш нааш нэг удаа нэвтрэх эрхийн 19553 үнэмлэх олгож улсын төсөвт 58.659.000 төгрөгийн орлогыг хуульд заасны дагуу төвлөрүүлжээ.

Гадаад зорчих эрхийн бүртгэлийн үйлчилгээ гадаад паспортын үйлчилгээг Сэлэнгэ аймгийн 17 сум 5 тосгонд бүрэн нэвтрүүлэв.



Сэлэнгэ аймаг нь Засаг захиргааны нэгжийн хувьд 17 сум 5 тосгонтой. Улсын бүртгэлийн онлайн сүлжээнд ороогүй Баруунбүрэн, Рашаант тосгон, Түнхэл тосгон, Дулаанхаан тосгонд 4G төхөөрөмжөөр бүртгэлийн үйл ажиллагааг иргэдэд үзүүлж байна.

Д/д	Бүртгэлийн төрөл	Сүм							Бүгд
		Дулаанхаан	Түнхэл	Рашаант	Бугант	Мандал	Сайхан	Баруунбүрэн	
1	Төрсний бүртгэл ИУБ-11	9	54	32	26	0	0	33	121
2	Гэрлсэний бүртгэл ИУБ-15	3	9	10	8	6		11	36
3	Гэрлэлт дуусгавар болсны бүртгэл - ИУБ-16	1	5	3	2			2	11
4	Үрчилсний бүртгэл ИУБ-12	2	4	0				1	6
5	Эцэг, эх тогтоосны бүртгэл ИУБ-14	5	2	2				2	9
6	Овог, эцэг, эхийн нэр өөрийн нэр өөрчилсний бүртгэл ИУБ-13	1	2	0				0	3
7	Нас барсны бүртгэл ИУБ-18	6	14	22	15			10	57
8	Иргэний үнэмлэх олголт -шинэ	17	54	47	46	3		39	167
9	Дахин	2	23	11	21	17	6	31	80
10	сунгалт	28	54	28	41	37	7	35	195
11	Дахин гэрчилгээ төрөлт	18	15	6	16	2		14	57
12	Гэрлэлт	2	2	2				0	6
14	Гадаад паспортын бүртгэл	45	80	102	145	2		64	374
15	Хил нэвтрэх үнэмлэх			0	16			0	16
16	Шилжилт хөдөлгөөний бүртгэл	18	265	87	64	5	0	70	439
17	Лавлагаа иргэнд	134	403	96	205			271	838
18	Төрийн байгууллага	35	82	69	5			172	191
19	Хууль хяналт		236	0		379		1	615
20	Тоон гарын үсэг	145	61	268	222	100	46		842
Нийт		471	1365	785	832	551	59	756	4063

Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 332 тоот тогтоолоор батлагдсан “Монгол улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу аймгийн хэмжээнд:

- ✓ баг хооронд шилжсэн – 1312 /хүүхэд -607/,
- ✓ сум хооронд шилжсэн–1537 /хүүхэд -238/,

✓ аймаг, нийслэлээс-1781 /хүүхэд-836/ иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хөтөлж хянан баталгаажуулан ажиллав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 3550, Газар өмчлөх эрхийн 3440, нийт 6990 мэдүүлэг хүлээн авчээ. Үүнд:

- ✓ Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэл -342
- ✓ Төрөөс үнэгүй хувьчилсан газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл-971
- ✓ Төрөөс хувьчилсан орон сууц -6
- ✓ Төрөөс худалдаж авсан газрын анхны бүртгэл-2
- ✓ Шинээр баригдсан орон сууцны -127
- ✓ Худалдах худалдан авах гэрээ- 2030
- ✓ Бэлэглэлийн гэрээ -265
- ✓ Гэрээслэл болон өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх гэрээ-280
- ✓ Арилжааны гэрээ -31
- ✓ Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх-6
- ✓ Өөрт оногдох хэсгээ худалдах, бэлэглэх хэлцэл -44
- ✓ Өөрт оногдох хэсгээс худалдах, бэлэглэх хэлцэл-119
- ✓ Үрэгдүүлсэн гэрчилгээ- 109
- ✓ Барьцааны гэрээ болон Барьцааны гэрээ дуусгавар болгох -7711
- ✓ Бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл- 516
- ✓ Бусад гэрээ-13
- ✓ Лавлагаа хуулбар, хувийн хэрэг хаах 246-н бүртгэлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд тус тус бүртгэлээ.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ний өдрийн Б/297 дугаартай тушаалаар Баянгол, Сант сумын улсын бүртгэгч нарт “ Эд хөрөнгийн бүртгэл хөтлөх эрх шинээр олгож үйлчилгээг үзүүлж эхлэв.



Баянгол сум	- Төрөөс үнэгй хувьчилсан газрын анхны бүртгэл 14
	Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 74
Сант сум	- Төрөөс үнэгүй хувьчилсан газрын анхны бүртгэл 10
	Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 5
Түшиг сум	- Төрөөс үнэгүй хувьчилсан газрын анхны бүртгэл 11
	Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл 4
Хүдэр сум	- Төрөөс үнэгүй хувьчилсан газрын анхны бүртгэл 24

Сумдын улсын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэлийг бүртгэл хөтлөх эрх олгогдсоноор :

- Мандал сум 22
- Жавхлант 28
- Хушаат 6
- Хүдэр 7
- Түшиг 3
- Сайхан 20 бүртгэл бүртгэгджээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн цахим үйлчилгээ болох E-Business-ийн хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажилт цэсэд байрлах оноосон нэр баталгаажуулах хүсэлт илгээсэн 2113 нэрийг Хуулийн этгээдийн мэдээллийн сан / ERS /-д шалган шаардлага хангасан 209 хуулийн этгээдийн нэрийн баталгаажилтыг хийсэн байна.

Тамга тэмдэг баталгааны тэмдэг хэвлэмэл хуудас хэрэглэх журам"-ын 6.17-д заасны дагуу 22 ширхэг тамга тэмдгийг төрийн архивд шилжүүлэхээр бэлтгэж ажиллалаа.

Архивын үйл ажиллагааны талаар:

Улсын бүртгэлийн эх нотлох, баримт бичгийг архивд хадгалах журам, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, чиглэлийг мөрдлөг болгон ажиллалаа.



Бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон цаасан суурьт эх нотлох баримтыг архивд хүлээн авах, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах хадгалж хамгаалах, ашиглуулах, мэдээлэл, хуулбар олгох ажлыг хийж гүйцэтгэлээ.


Бүртгэлийн үйл ажиллагааны явцад бий болсон цаасан суурьт эх нотлох баримтыг архивд хүлээн авах, эмхлэн цэгцлэх, нягтлан шалгах хадгалж хамгаалах, ашиглуулах, мэдээлэл, хуулбар олгох ажлыг хийж гүйцэтгэлээ. Тайлангийн хугацаанд иргэний бүртгэлийн тасгаас хүлээн авч буй цаасан суурьт баримтыг дэс дараалал, бүртгэлийн дугаарыг нэг бүрчлэн нягтлан шалгаж архивын санд хүлээн авлаа.

Архивын хадгаламжийн санд иргэний бүртгэлийн тасгаас нийт 10 төрлийн 6778 ширхэг ИУБ хүлээн авснаас:

№	Маягтын төрөл	2025 онд
1	ИУБ-11	1011
2	ИУБ-12	24
3	ИУБ-13	39
4	ИУБ-14	57
5	ИУБ-15	233
6	ИУБ-16	97
7	ИУБ-18	479
8	ИУБ-31	2990
9	ИУБ-22	1846
10	ИУБ-25	2
	Дүн	6778

Архивын сан хөмрөгт хүлээн авсан иргэний гэр бүлийн бүртгэлийн маягыг сүүлийн 3 жилийн байдлаар үзүүлбэл





ИУБ-11, ИУБ -18, хувийн хэргийн санд баяжилтыг цаг тухайд нь байршуулж байна.

Түүнчлэн 17 сум 5 тосгоны иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 2024 онд бүртгэл хөтөлсөн 158 бүртгэлийн дэвтэр, иргэний бүртгэлийн тасгаас гадаад паспорт олголтын 25 , сумдад олгосон иргэний үнэмлэхийн жагсаалт, иргэний үнэмлэхийн бүртгэл хөтөлсөн , тоон мэдээ 7 нийт 176 хадгаламжийн нэгжийг дагалдах хуудасны дагуу бүртгэлийн төрөл, дэс дараалал , галигласан байдал, товъёоор нэг бүрчлэн нягтлан тулгаж архивын санд хүлээн авч байршуулсан байна.

Сэлэнгэ аймагт шилжин ирж суурьшсан 443 иргэний хувийн хэргийг хүлээн авч байршуулаа.

Сэлэнгэ аймгаас бусад аймаг, нийслэл рүү шилжин суурьшсан 926 иргэний хувийн хэргийг харьяа орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэст албан бичгээр хүргүүлсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивд 2025 онд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө 22056, газар өмчлөх эрхийн 37541, газар ашиглах эзэмших эрхийн 16352, нийт 75949 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын мэдүүлэгт хүлээн авч бүртгэсэн өмчлөх эрх шилжүүлэх гэрээ, хэлцэл, барьцааны гэрээ, барьцааны эрх дуусгавар болох, бусад бүртгэл нийт 11304 ширхэг бүртгэлийг /архивд хүлээн авсан бүртгэлийн дэвтэр/-т бүртгэж тухай бүрд нь хувийн хэрэгт материалын баяжилтыг хийж ажиллаа.

Мөн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивд тайлангийн хугацаанд улсын бүртгэгч нарын бүртгэсэн үл хөдлөх хөрөнгө, газар өмчлөх эрхийн анхны бүртгэлийн 1682 ширхэг хувийн хэргийг бүртгэлийн дэвтэр /маягт А1/-т хөтлөн, хяналтын байцаагчаар хянуулан хүлээн авч, эрхийн улсын бүртгэлийн дугаараар ялгаж, дугаар бүхий хавтсанд хийж зориулалтын тавиурт байрлуулж хүлээн авлаа.


Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивд хадгалагдаж байгаа улсын бүртгэгч нарын архивд хүлээлгэн өгсөн 2013-2022 он хүртэлх үл хөдлөх хөрөнгө болон газрын бүртгэлийн 139 ширхэг гэрчилгээнээс 6 ширхэг гэрчилгээг иргэнд олгож ЭУБ-12 бүртгэлийн дэвтэр хөтөлж ажиллав.

Архивын ерөнхий газрын даргын 2010 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн №А/13-т “Цаасан баримтыг сэргээн засварлах ажлын заавар батлах тухай” тушаалын 4.3.5-д заасны

дагуу сэлбэх нотлох баримтын цаасны зах ирмэг урагдаж салбарсан, тасарч алга болсон, үдэлт нь сэтэрсэн, үжирсэн зэрэг гэмтэлтэй хэсгийг нөхөн сэлбэж тухай бүрд нь засаж байршуулсан бөгөөд баримтыг нөхөн сэлбэх ажлыг шат дараалан хийж гүйцэтгэж байна.



Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэлийн архивд ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна. Үүнийг графикаар харуулбал:



Хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэгч нарын мэдээллийн санд бүртгэсэн нэмэлт өөрчлөлтийн 189 бүртгэл, шинээр бүртгүүлсэн хуулийн этгээдийн 435 бүртгэлийг архивд хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт бүртгэж тухай бүр хувийн хэрэгт баяжилтыг хийж, хяналтын

байцаагчаар хянуулан хүлээн авч, эрхийн улсын бүртгэлийн дугаараар нь ялгаж, дугаар бүхий хавтсанд хийн, эрхийн улсын бүртгэлийн дугаарын дарааллаар зориулалтын тавиурт эмх цэгцтэй байрлуулж хадгалж ажиллаа.

Хууль зүйн дотоод хэргийн сайдын 2018.11.19-ны өдрийн А/216 тоот “Тамга тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам батлах тухай” тушаалын 9.4, 9.5 дахь заалтыг үндэслэн хуулийн этгээдийн бүртгэлийн архивд 79 тамга тэмдэг хадгалагдаж байна.

Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралт “Тамга, тэмдгийн баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, журам”-ын 6.17-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлд дээрх журмын 2.1.11, 2.1.12, 2.1.15-д заасан байгууллагуудын хураалгасан тамга, тэмдэг болон 22 ширхэг тамга тэмдэгийг аймгийн засаг даргын тамгын газрын хууль зүйн хэлтсийн архивын тасагт хүргүүлэн өгөхөөр бэлдэж ажиллалаа.

Харьяаллын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт болон харьяа орон нутаг руу шилжиж хаягийн өөрчлөлт бүртгүүлсэн шилжиж явсан 11 тус аймагт харьяаллын дагуу шилжиж ирсэн 17 ширхэг хуулийн этгээдийн хувийн хэргийг архивд хүлээн авч байрлуулж ажиллалаа.

ХОЁР. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны жилийн дэд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хяналт шалгалтын чиглэлээр дараах ажиллагааг хийж гүйцэтгэлээ.Үүнд:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:


Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр нийт 4249 бүртгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд улсын бүртгэлийн зөрчил арилгуулах талаар хүсэлт гаргасан нийт 15 иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, улсын байцаагчийн 19 дүгнэлт үйлдэж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт цахим болон цаасан хэлбэрээр хүргүүллээ.

202 онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр аймгийн хэмжээнд хөтлөгдсөн нийт 12 төрлийн 2766 бүртгэлийг татаж, бүртгэлийн дэвтэр, нотлох баримтын бүрдүүлбэр, цахим мэдээллийн сантай тулган төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

Тайлангийн хугацаанд иргэний үнэмлэх дахин олголтын болон биеийн давхцахгүй өгөгдлийн 154, үндэсний энгийн гадаад паспортын 220 бүртгэлд өдөр тутмын хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах талаар хяналтын улсын байцаагчийн 2 дүгнэлт үйлдэн бүртгэлд өөрчлөлт оруулав.

Тус хэлтсийн хэмжээнд Алтанбулаг, Сүхбаатар, Орхонтуул, Сайхан, Жавхлант, Баруунбүрэн сумдад 2025 оны 01 дугаар сарын 01-ны өдрөөс 04 дугаар сарын 23-ны өдрийг дуусталх хугацаанд бүртгэгдсэн иргэний шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд зөрчил илрээгүй болно.

Иргэний улсын бүртгэлд хяналт тавьсан бүртгэлийн тоо.




Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр газар болон үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн 1265 хувийг хэрэг, барьцааны гэрээ, хэлцэлд байнгын хяналт тавьж ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах явцад нийт 5 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгасан ба үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой хяналтын улсын байцаагчийн 121 дүгнэлт үйлдэж, Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлсэн.

Хяналт шалгалтын дэд төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Мандал сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын сар бүр эрхлэн хөтөлсөн бүртгэлд цахим хэлбэрээр тогтмол хяналт, шалгалтыг хийж эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн нотлох баримтын бүрдүүлбэр, цахим мэдээллийн сан дахь мэдээллийг шалгаж, алдаа дутагдал, анхаарах асуудлын талаар улсын бүртгэгч нарт чиглэл өгч, илэрсэн зөрчлийг тухайн улсын бүртгэгч тус бүрээр газар дээр нь арилгуулах арга хэмжээг авч ажиллалаа.


Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр хяналт тавьсан бүртгэлийн тоо, зөрчлийн тоон харьцуулалт.



Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 464 бүртгэлд хяналт тавьж ажилласан бөгөөд сар бүр бүртгэгдсэн бүртгэлд өөрчлөлт оруулсан болон анхны бүртгэлийн нотлох баримтад тогтмол хяналт тавьж, тамга тэмдгийн хяналтын дугаар хүчингүй болгох тухай 2 дүгнэлт үйлдсэн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр хяналт тавьсан байдал



Улсын бүртгэлийн архивын чиглэлээр

Улсын бүртгэлийн архивын хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, хувийн хэргийн иж бүрдэлд түүвэрчилсэн байдлаар хяналт тавьж, архивын 128 хувийн хэргийн бүрдлийг шалгав.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын хүлээн авсан мэдүүлгийнх нь дагуу архиваас татаж шалгасан 45 хувийн хэрэг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 58 хувийн хэргийг хянаж хувийн хэргийг цахим санд оруулах ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллалаа.

Архивын баримтад хяналт тавьсан байдал



Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын талаар:

Улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгах зорилтын хүрээнд 7 заалт бүхий хяналт шалгалтын дэд төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт 5, гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 5, өргөдөл гомдлын мөрөөр 159 шалгалт хийж, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 6, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 57, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 1, нийт 64 дүгнэлт үйлдэж бүртгэлийн зөрчлийг арилгасан болно.

Зөрчлийн болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Хяналтын улсын байцаагчаас Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 235 хүн, 2 хуулийн этгээдэд “Зөрчлийн тухай” хуулийн холбогдох заалтыг баримтлан хялбаршуулсан журмаар 5.445.000 төгрөгийн шийтгэл оногдуулж, орон нутгийн орлогод төвлөрүүлсэн бөгөөд давагдашгүй нөхцөл байдлын улмаас 1 хүний зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэв.

ГУРАВ. 2025 ОНЫ АЙМАГ НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН НӨХӨН СОНГУУЛЬ:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулиар улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, УБЕГ-ын ирүүлсэн чиглэлийн дагуу АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн “Нөхөн сонгууль товлон зарлах тухай” тогтоолыг 7 сумын ИТХ-аас хүлээн авч хяналт тавин 10 санал авах байр, хаягийн мэдээллийг шивж баталгаажуулан тогтоолын эх хувийг ИУБ-ийн газарт хүргүүлэв.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгууль товлон зарлах тухай тогтоолын дагуу тухайн сонгуулийн хэсэгт хамаарах нутаг дэвсгэр байр, гудамж бүрэн хамрагдсан эсэх, хаяг оноогдсон байдлыг нягтлан шалгахад 16-1-7 дугаар хэсгийн хороонд 18 хаяг, 16-2-1 дүгээр хэсгийн хороонд 16 хаяг, 16-2-2 дугаар хэсгийн хороонд 6 хаяг, 16-3-2 дугаар хэсгийн хороонд 11 хаяг, 16-6-2 дугаар хэсгийн хороонд 8 хаяг, 16-10-1 дүгээр хэсгийн хороонд 12 хаяг, 16-10-3 дугаар хэсгийн хороонд 2 хаяг, 16-11-1 дүгээр

хэсгийн хороонд 14 хаяг, 16-11-2 дугаар хэсгийн хороонд 14 хаяг, 16-17-3 дугаар хэсгийн хороонд 6 хаяг, нийт 97 хаяг бүртгэгдээгүй байсныг санал авах байранд нэмж баталгаажуулав.

3. 2024 оны 10 дугаар сарын 12-оос хойш шилжилт хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан зарим иргэд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй байсан бөгөөд дахин ирсэн сонгогчдийн нэрийн жагсаалтад шилжин ирсэн иргэд бүртгэгдсэн байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/71 дугаартай “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” тушаалын дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Иргэний шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг зогсоохтой холбогдуулан заавар зөвлөмжийг нийт улсын бүртгэгч нарт хүргүүлэв.

2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш хийгдсэн 833 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл бүрэн бүртгэгдэж баталгаажсан эсэхэд хяналт тавин ажиллалаа.

Шилжин суурьших хөдөлгөөний бүртгэл хийлгэснээс санал авах байранд бүртгэгдээгүй хаягийн жагсаалтад 25 хаяг, сонгогчдын нэрийн жагсаалтад хэсэг оноогдоогүй байсан 46 иргэнийг нэмж тухайн сонгуулийн хэсгийн хороонд бүртгэж баталгаажуулснаар АНСДИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад аймгийн хэмжээнд сонгуулийн насны 11905 иргэн бүртгэгдсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20.6-д заасан байгууллагаас ирүүлсэн 176 иргэний мэдээлэлд “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн байна. Үүнд:

- Эрх зүйн чадамжгүй 6 иргэн
- Тусгай анги салбарын алба хаагч ажилтан 47 иргэн
- Цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги 13
- Хорих анги, эрүүгийн хэрэг, албадан эмчлүүлсэн 19 иргэн
- Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон 712 иргэн


Дээрх “Түр хасав” нэмэлт тэмдэглэгээтэй сонгогчдын мэдээллийг тулган шалгахад өмнөх сонгуулиудад түр хасав нэмэлт тэмдэглэгээтэй байсан гадаад улсад зорчиж байгаагүй 15 иргэн, гадаад улсад зорчоод ирсэн 6 иргэн, хорих ангид ял эдэлж байгаад суллагдсан 1 иргэн зам явах хуудастай биечлэн ирж хүсэлт гаргасан тул түр хасав нэмэлт тэмдэглэгээг сэргээсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаар гомдол мэдээлэл ирээгүй болно.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Сонгуулийн тухай хуулийг /нөхөн/ хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний Улсын бүртгэлийн газраас ирүүлсэн чиглэл, Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан ажил үүргийн хуваарийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийн 16 дугаар тойргийн 10 хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр 2 хувь хэвлэв.



Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуулийн 16 дугаар тойргийн 10 хэсгийн хорооны сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгаж 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлцэх акт үйлдэн сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлээ.




Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх явцад алдаа зөрчил гараагүй бөгөөд аймгийн хэмжээнд үндсэн сонгогч 11126, түр хасав нэмэлт тэмдэглэгээтэй 775 сонгогчдын нэрийн жагсаалтад нийт 11901 сонгогч бүртгэгдсэн байна.

ДӨРӨВ.ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Тайлант онд улсын төсвөөс байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардалд 1678887.1 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсон байна. Батлагдсан төсвийн 90%-ийг Төсвийн тухай хууль, УСНББОУС болон бусад хууль тогтоомжийн дагуу зарцууллаа.

№	Зардлын зүйл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1678887100	1599095199.23
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1678887100	1599095199.23
3	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1678887100	1599095199.23
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1442216500	1410253061
5	Нийгмийн даатгалын шимтгэл	200350600	156026415
6	Гэрэл цахилгаан	1903200	1903200
7	Түлш, халаалт	11477800	9968400
8	Цэвэр, бохир ус	820000	540000
9	Байрны түрээс	820000	785400
10	Бичиг хэрэг	12600900	12463350
11	Тээвэр шатахуун	2500000	2180000
12	Шуудан холбоо интернэтийн төлбөр	2765600	2062773
13	Хог хаягдал зайлуулах, хортон	18100	
14	Бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс	794100	799600
15	Багаж, техник хэрэгсэл	317000	317000
16	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	72100	
17	Урсгал засвар	72000	72000
18	Дотоод албан томилолт	560000	560000
19	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100000	100000
20	Тээврийн хэрэгслийн татвар	90000	
21	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	799100	484000
22	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800100	680000
23	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж		



2025 оны онд 851 нэр төрлийн 658787.7 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэйгөөр үйл явуулж байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт, татварын тайлан, нийгмийн даатгалын тайлан зэрэг бусад холбогдох мэдээл тайланг хуулийн хугацаанд нэгтгэн тайлагнасан.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дугаар 384 тогтоол, Шилэн дансны тухай хууль 3.1.4 3.2.4 –т заасны дагуу сар бүрийн төсвийн зарцуулалттай холбоотой ажил гүйлгээг сар бүрийн 8-ны дотор “Шилэн дансны систем” болон Санхүүгийн ил тод байдлын самбарт байршуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 28 төрлийн 148 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаад байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар shilen.gov.mn веб хуудасны гүйцэтгэл 80% мэдээлэлсэн байна.

Аудитын албан шаардлагын биелэлтийн хуулийн хугацаанд гаргаж Сэлэнгэ аймгийн аудитын газарт хүргүүлэв.


Д/д	ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГА	АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ
1	Багаж, техник хэрэгслийн зардлаас урсгал засварын зардалд 206.4 мянган төгрөгийг зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй. Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллаж, биелэлтийг тайлагнах.	Эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлээр багаж техник хэрэгслийн зардал 317.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдэж төсвийн зориулалтын дагуу зарцуулсан байна.
2	Өмнөх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан ахлах нягтлан бодогч М.Мягмарт холбогдох хуулийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах.	Хэлтсийн даргын 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн Б/08 тушаалаар ахлах нягтлан бодогч М.Мягмарт нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл оногдуулсан байна.

ТАВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН 85 ЖИЛИЙН ОЙ, СЭЛЭНГЭ АЙМАГ 2025 ОНЫГ “БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ-НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” БОЛГОН ЗАРЛАСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН ХАМТ ОЛНООС ХИЙСЭН БҮТЭЭЛЧ АЖЛУУД:


Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойн хүрээнд, албан хаагчдын ажлын байрны нөхцөлийг сайжруулан хэлтсийн албан хаагчдад 6 үйлдэлт сандал 20 ширхэг, мөн сургалтын танхимд сургалтын тавиур бүхий 30 сандлыг орон нутгийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэлээ.



Хэлтсийн сургалтын танхимд ус алдаж ашиглах боломжгүй болсон тул засварын ажлын тооцоог гарган Засаг даргад хүргүүлэн 4,5 сая төгрөгийн засварын ажлыг хийж тохижуулав.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэн ажиллаж байгаа билээ. Энэ төсөл хөтөлбөрийн хүрээнд хэлтсийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан үйлчилгээний танхим болон хуулийн этгээдийн улсын бүртгэгч, бичиг хэргийн ажилтны бичиг баримт хадгалах шүүгээг стандартын шүүгээгээр солив.



Албан хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулахад 16,650,000 төгрөгийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэжээ.

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын ээлжит VII-р хуралдаанаар Сэлэнгэ аймгийн 2026 оны “Сэлэнгэ аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г баталж иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цогц хэлбэрээр хурдан шуурхай анхан шатнаас үзүүлэхэд сумдад ажиллаж байгаа 25 улсын бүртгэгчийн тоног төхөөрөмжийг шинэчлэх хөрөнгийг шийдвэрлүүлэв.

Сэлэнгэ аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн 2025 оны 01 дугаар хуралдаанаар Сэлэнгэ аймгийн Мандал болон Сайхан суманд байрлах 413,433.435 дугаар Хорих ангиудад ял эдэлж байгаа хоригдлуудыг бичиг баримтжуулах улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэхэд 3 ширхэг Starlink төхөөрөмжийг ашиглалтын зардлын хамт шийдвэрлүүлж төхөөрөмжийг Улсын бүртгэлийн ерөнхий газраас хүлээн авч Сэлэнгэ аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Г.Бат-Орхонд хүлээлгэн өглөө.



Олон улсын ахмадын өдрийг тохиолдуулан 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдөр хамт олны санаачилгаар "ХИШИГ ӨДӨР" арга хэмжээг хэлтэс, Хушаат сум, Ерөө сум, Орхонтуул сум, Бугант тосгонд тус тус зохион байгууллаа. Ахмад албан хаагчид маань улсын бүртгэгч нарынхаа заавар зөвлөгөө дор улсын бүртгэлийн цахим мэдээллийн системтэй танилцан,

иргэдэд зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж ажиллагаа. Ахмад албан хаагч нартаа "ХИШИГ ӨДӨР"-ийн цалингаар урамшууллаа.



Архивын нэгдсэн байдлыг ханган ажиллахад Мандал суманд байрлаж байсан Мандал Баянгол сумын эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 17605 хувийн хэрэг, Сайхан суманд байршиж байсан / Баруун 5 сумын/ 11950 ширхэг хувийн хэргийг хэлтсийн архивд шилжүүлэх арга хэмжээний хүрээнд:

1. Тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тасгийн даргаар ахлуулсан баг 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр Сэлэнгэ аймгийн Сайхан суманд 2025 оны 09 дүгээр сарын 30-аас 10 дугаар сарын 01-ны өдрүүдэд 4250 ширхэг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн

архивын хувийн хэргийг цахим мэдээллийн санд тулгалт хийж, хуудасны тоог тоолж ангилан ялгаж ажиллалаа.

2. Дархан-Уул аймгийн улсын бүртгэлийн хэлтэс байсан нягтруулсан 6 иж бүрдэл /хуучин/ шүүгээг шилжүүлэн байршууллаа.
3. Сэлэнгэ аймгийн Сайхан сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 11950 хувийн хэрэг, тусгаарласан материал, бүртгэлийн дэвтэр зэргийг 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр
4. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивч Д.Нарантуяа 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Мандал, Баянгол, Түнхэл тосгоны улсын бүртгэгч нар, Мандал сумын Засаг даргын тамгын газрын албан хаагч нартай хамтран архивын хувийн хэргийн тооллого зөөвөрлөхөд бэлтгэлээ.
5. 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Мандал сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 17605 хувийн хэрэг, тусгаарласан материал, бүртгэлийн дэвтэр зэргийг төмөр тавиуруудын хамт зөөвөрлөж байршуулав.







Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын“ Албан даалгавар хүргүүлэх тухай” 2025.09.30-ны өдрийн 1/11299 дугаартай албан бичгийн дагуу “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх” дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Монгол улсын засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 23 дугаар тогтоол, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны А/153 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “ Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх урьдчилсан үзлэг явуулах төлөвлөгөө”–ний дагуу хэлтсийн даргын 2025.09.11-ний өдрийн “ Ажлын хэсэг байгуулах тухай” А/06 дугаартай тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх багийг байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газраас 2025.09.04-ны өдөр 02/640 дугаартай албан бичгээр “Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамж”-ийн 2.2.1-т заасны дагуу хууль зүй дотоод хэргийн сайд, Төв комиссын даргын баталсан төрийн байгууллагын архив албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн дүгнэх үзүүлэлт, аргачлал, улсын үзлэгийг орон нутагт зохион

байгуулах тухай хуваарь, аймгийн Засаг даргын 2025.09.03-ны өдрийн А/426 дугаартай “ Дэд комисс томилж, үзлэгийн хуваарь батлах тухай” захирамж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Төв комиссын даргын баталсан үзлэгийн дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу аймгийн засаг даргын томилсон дэд комисс 2025.09.19-ны өдөр тус хэлтсийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтад үзлэг, шалгалт хийлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг архивч, хэлтсийн нийт албан хаагчдад / ZOOM/ цахим хурлаар танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

1.Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан” Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын 2.2.1.3 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалаар батлагдсан “ хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн байгууллагын дэргэдэх байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссын 2025 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн хурлаар хэлэлцсэн “ Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг баталлаа.

Хэлтсийн даргын баталсан “ Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг нийт албан хаагчдад танилцуулан, 2025 оны үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг үүрэг болгов.

2.Байгууллагын архивын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу баримтын хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, сан хөмрөг бүрдүүлэх, баримтыг албан ажлын хэрэгцээнд ашиглуулах, тайлагнах ажлын хүрээнд хэлтсийн 2025 оны жилийн төлөвлөгөөний хүрээнд архивын чиглэлээр хийж гүйцэтгэх 20 заалт бүхий ажлын төлөвлөгөөг баталлаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас батлагдсан албан тушаалын тодорхойлолтод албан хэрэг хөтлөлтийн талаарх хүлээх үүргийг тусгаж өгсөн бөгөөд хэрэгжилтийг хөдөлмөрийн гэрээ дүгнэхдээ үзүүлэлт тус бүрээр дүгнэж хэвшсэн болно.

Бичиг хэргийн ажилтныг албан хэрэг хөтлөлтийн талаар сургаж мэргэшүүлэх, чадавхжуулах талаар удирдлагаас тухай бүр арга хэмжээ авч ажиллаж байна. 2025 онд “Монсэгү” ХХК болон аймгийн архивын хэлтсээс хамтран 2025.09.05-ны өдөр зохион байгуулсан “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт” сэдвээр 1.5 кредитийн сургалтад / бичиг хэргийн ажилтныг/ хамрагдаж №592 дугаартай батламж авлаа.



Хэлтсийн албан бичгийг Монгол улсын засгийн газрын 2020 оны “Үндэсний хөтөлбөр батлах тухай” тогтоолын дагуу үндэсний бичгээр хөрвүүлэх “Кимо” программыг 2025- оны 09 дүгээр сарын 05 ний өдөр албан хэрэг хөтөлөлтийн хэрэглээнд нэвтрүүлж 2025 онд гарсан жижиг бланк 410, том А4 бланк 275 хөрвүүлэлтийг нөхөн хийж архивын стандартыг хангаж ажиллаа.

Хэлтсийн нийт албан хаагчдад <https://erp.e-mongolia.mn> цахим программаар албан бичиг, тогтоол , шийдвэрийг түргэн шуурхай хүргүүлж ажиллаж байгаа бөгөөд хариутай албан бичгийн хариуг хэлтсийн дарга хянаж тоон гарын үсгээр баталгаажуулан хэлтсийн үйлчилгээний танхим болон Сайхан, Мандал сумдын улсын бүртгэгч нарт интернэтийн орчин ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэн хуулийн байгууллагад олгогдох лавлагаа мэдээллийг шуурхай гарган хүргүүлж байна.

Архив, бичиг хэргийн ажилтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа Del OptiPlex 3080 марктай компьютерын 8GB RAM-ийг 16GB, нэмэлтээр 3TB хатуу дискийг нэмж багтаамжийг нэмэгдүүлэв.

“Ногоон хөгжлийн бодлого-2030” бодлогын баримт бичгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 13 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд бүх шатны төрийн байгууллага хэрэгжилтийг нь ханган ажиллаж байгаа ба тус хэлтсийн байрлаж буй Нутгийн захиргааны 3 дугаар байрны гадна хэсэг, нийтийн эзэмшлийн талбайд албан хаагчид голт бор 10 ширхэг, монос 10 ширхэг нийт 2 төрлийн 20 ширхэг мод тарьж, цэцэгжүүлэлтийн мандлын ажлыг хийж гүйцэтгэлээ.



Хэлтсийн байрны гадаад орчны тохижилтыг сайжруулан 8 цэцгийн мандал хийж арчлан ургууллаа.



Сумдад ажиллаж байгаа улсын бүртгэгч нар “Тэрбум мод” хөдөлгөөн болон хоггүй Сэлэнгэ аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын 2025 онд тэр бум модны хүрээнд хийсэн ажлын судалгаа																			
№	Сумдын нэрс	Хөг цэвэр лэсэн	Тасалгааны цэцэг тарьсан	Түймэрт ажилласан	Хүнсний ногоо тариалсан	модны төрөл												Нийт	
						Агч	Голт бор	Хуш	Гацуур	Нарс	Чацаргана	Бургас	Сакура	Ухрийн нүд	Монос	Улаалзгана	Шинэс		Суулгац
1	Алтанбулаг сум	1	5	0	0	5	4					85						100	
2	Баянгол сум	2	3	0	0	2								2	2			11	
3	Баруунбүрэн сум	3	2	1	0	0												6	
4	Ерөө сум	2	0	0	0	0		2	2	3	4							13	
5	Бугант тосгон	3	0	0	0					18					100			121	
6	Жавхлант сум	2	0	0	0	2						2	4					10	
7	Зүүнбүрэн сум	2	5	1	2	0	3			2				5				20	
8	Мандал сум	1	24	0	6	30	25	20	15	10	5		1	5	10	5	6000	2000	8157
9	Түнжэл тосгон	1	1	1	0	0		5		2								11	
10	Орхон сум	2	0	0	0	0												7	
11	Орхонтүүл сум	0	0	0	0	0												0	
12	Орхонтүүл сум	3	0	2	5	10								5				25	
13	Сайхан сум	2	0	0	1	5												8	
14	Сэнт сум	2	10	0	0	0			5	5				2		2		26	
15	Сүхбаатар сум	1	6	0	0	0												7	
16	Түшиг сум	2	3	2	4	0								4	1			16	
17	Хушваат сум	2	3	2	0	0				7					2			16	
18	Хүдэр сум	1	8	0	0	0												9	
19	Цагааннуур сум	2	2	2	4						2			3				15	
20	Шаамар сум	2	0	0	3	0								5				10	
21	Дулаанхаан тосгон	2	3	0	3						5			5				18	
22	Хэлтсийн албан хаагчид	2	6	0	5		10			4				5	10			42	
Нийт		40	81	11	33	54	43	22	24	45	16	87	5	41	115	7	6000	2000	8624

Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ой “Тэрбум мод” хөдөлгөөний хүрээнд албан хаагчид 2025 оны 5 сард мод тарих өдрөөр 11 төрлийн 148 мод тарьж ургуулжээ.





Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 02 сарын 27-ны өдрийн 02/198 тоот, 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/128 тоот захирамжийн дагуу бүх нийтийн хог цэвэрлэх арга хэмжээнд нийт 17 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийтийн эзэмшлийн талбайд болох Сүхбаатар сумын 8 дугаар багт байрлах “Карьерийн баруун урд булан болох Номтын уулзварын хэсгийн хуваарьт газрын 170 кг хог хаягдлыг цэвэрлэж төвлөрсөн хогийн цэгт буулгаж ажиллалаа.



Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын гурав дугаар багийн нутаг Хярааны голын эрэг дагуух газарт гол, горхины ай савыг хамгаалах зорилгоор улсын бүртгэгч Ж.Нарангэрэл “Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн нэрэмжит төгөл”-ийг байгуулж 85 бургас модыг тарилаа.



Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ний 01/608 дугаартай "Хамтран ажиллах тухай" албан бичгийн хавсралтаар ирүүлсэн хуваарийн дагуу Нутгийн захиргааны 3-р байрны урд хавар тарьсан модныхоо ойр орчмыг цэвэрлэж, мод бут сөөгийг арчлан, "ЦЭНЭГ" усалгааг хийлээ.





Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 14-ний А/313 дугаартай "Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажил зохион байгуулах тухай" захирамжийн дагуу тус хэлтсийн хамт олон Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын 3 дугаар багийн нутаг Карьерын урд булангаас Номтын уулзвар хүртэлх урт нь 2.5 км, өргөн нь 0.5 км нийт 29 га талбайн хогийг цэвэрлэж ажиллалаа.





Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газар, бие бялдарын түвшин тогтоох сорилын төвтэй хамтран 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр өдөрлөг зохион байгуулсан бөгөөд хэлтсийн албан хаагчид биеийн тамирын сорил өгөв.



Монгол улсын засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар, салбарын хөдөө орон нутагт ажиллаж буй алба хаагчид болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрт илрүүлэг хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий “ХАМГИЙН ЧУХАЛ НЬ ЭРҮҮЛ МЭНД” зорилтот арга хэмжээний 3 дугаар ээлжийн үзлэг 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдөр хэлтсийн албан хаагчид гэр бүлийн гишүүдийн хамт 20 хүн үүнээс сумын улсын бүртгэгчдийн гэр бүл 12 хүн хамрагдлаа.



ЗУРГАА. ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Орхонтуул сумын Рашаант тосгоны Захирагчийн албанаас 2025 оны 10 дугаар сарын 20-ний өдөр зохион байгуулсан "Рашаантад үйлдвэрлэв" үзэсгэлэн худалдаан ирсэн иргэдэд улсын бүртгэгч Э.Дэлгэрцогт улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээг угтан Мандал сумын улсын бүртгэгч Б.Бүрэнтөгсөө, Түнхэл тосгоны улсын бүртгэгч Д.Баасансүрэн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч Ш.Энх-Амгалан нар 2025 оны 10 дугаар сарын 18-ний өдөр Мандал сумын алслагдсан Тарни 8 дугаар багт бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээг угтан Баруунбүрэн сумын улсын бүртгэгч Н.Отгонжаргал 2025 оны 10 дугаар сарын 15-ний өдөр Баруунбүрэн сумын 1-р цэцэрлэг, 10 дугаар сарын 16-ний өдөр Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, эцэг эхчүүд болон төгсөх ангийн 10,11,12 ангийн сурагчдад бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээг угтан Рашаант тосгоны улсын бүртгэгч Э.Дэлгэрцогт 2025 оны 10 дугаар сарын 15-ний өдөр Орхонтуул сумын Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчид, эцэг эхчүүд болон төгсөх

ангийн 10,11,12 ангийн 28 сурагчдад бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээг угтан Дулаанхаан тосгоны улсын бүртгэгч М.Мөнхмаа 2025 оны 10 дугаар сарын 15-ний өдөр алслагдсан төмөр замын Ерөө өртөөний иргэд, албан хаагчдад бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.



Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээг угтан Мандал сумын улсын бүртгэгч Б.Бүрэнтөгсөө, Түнхэл тосгоны улсын бүртгэгч Д.Баасансүрэн, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн улсын бүртгэгч Д.Лхагвасүрэн нар 2025 оны 10 дугаар сарын 16-ний өдөр Мандал сумын Хэрх тосгонд бүртгэлийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгаас Сэлэнгэ аймгийн Цагаануур, Түшиг, Зүүнбүрэн сумдын улсын бүртгэгч нарт 2025 оны 11 сарын 03-наас 04-ны өдрүүдэд Эд хөрөнгийн бүртгэлийн цахим мэдээллийн сан, хуулийн этгээдийн бүртгэлийн цахим санд бүртгэл хийх арга, зүйн сургалтыг хийж иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллалаа.



Сэлэнгэ аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн нээлттэй-хаалттай 413 дугаар хорих анги, Хаалттай 433 дугаар ангиудад Хэлтсийн дарга Б.Саранчимэг улсын бүртгэгч Б.Бүрэнтөгсөө нар бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.



ДОЛОО. ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР:

Хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой ирсэн, албан бичиг, өргөдөл гомдол, санал, хүсэлтийг бүртгэж авч тайлан мэдээг улирал бүр гаргаж Улсын бүртгэлийн Ерөнхий газарт болон орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагуудад цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлэв.

Бичиг хэргийн эргэлтийг Erp.e-mongolia.mn selenge@burtgel.gov.mn, 21aimag@burtgel.gov.mn, saranchimeg.b@burtgel.gov.mn, цахим хаягуудаар хүлээн авч шийдвэрлэж ажиллалаа.

2025 онд иргэдээс иргэний улсын бүртгэлтэй холбоотой болон цахим санд бүртгэл ороогүй, регистрийн дугаар болон нас зөрүүтэй, гэрлэлтийн бүртгэл санд ороогүй, мэдээллийн санд яс үндэс зөрсөн, ургийн овог зөрсөн, нас баралт нөхөн бүртгүүлэх, хурууны хээ танигдахгүй байх, огт бичиг баримтгүй зэрэг, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр, санхүү бүртгэлийн чиглэлээр данс андуурах, гүйлгээ андуурах, илүү төлбөр хийх зэрэг асуудлуудаар хандан өргөдөл хүсэлт ирүүлсэн 346 өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газар, төрийн байгууллага болон бусад хуулийн этгээдээс нийт 656 албан бичиг ирснээс ERP 620 бичиг, цаасан хэлбэрээр 36-ийг хүлээн авч бүртгэлийн дэвтэрт бүртгэн албан хаагчдад танилцуулж хяналт тавьж ажиллажээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газар бусад төрийн байгууллагуудад ERP программыг албан хаагч бүр ашиглан албан бичгийг боловсруулж E-token тоон гарын үсгээр баталгаажуулан албан бичгийг хүргүүлэн ажиллажээ.

НАЙМ. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Улсын бүртгэлийн сүлжээний аюулгүй байдал, мэдээллийн сангийн нууцлал, улсын бүртгэгч нарын тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагааг ханган, гэмтлийг засварлан үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж байна. Үүнд:

1. Мандал сумын дотоод сүлжээнд ашиглаж буй шилэн кабель гэмтсэн байсныг илрүүлэн засварын хугацаанд 4G төхөөрөмжийг байршуулан үйлчилгээг үзүүлж, “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК Дархан-Уул аймгийн газарт албан бичгээр хүсэлт гарган гэмтлийг засварласан;

2. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ний Дархан-Уул аймгийн газраас шилэн кабелийн засварын улмаас Баруун бүсийн сумдын сүлжээ 2025.05.14 болон 2025.05.27-ний өдрүүдэд 11:00-18:00 цагийн үеүдэд дотоод сүлжээ түр тасалдсаныг;

3. Сант сумын дотоод сүлжээнд ашиглаж байсан сүлжээ хүлээн авагч төхөөрөмж /media converter/ тогны хэлбэлзлээс үүдэн удаа дараа гэмтсэнийг хэлтсээс А болон В талын хоёр талын төхөөрөмжийг шинээр сольж;

4. Хэлтэс, сумдын албан хаагчдаас программ хангамж болон мэдээллийн сүлжээнд гарсан нийт 15 дуудлага хүлээн авч бусад гэмтлүүдийг тухай бүр утсаар болон дүрс дуудлагаар холбогдож 12 гэмтлийг засварласан;

5. Баянгол, Хүдэр, сумын дотоод сүлжээнд ашиглаж байсан сүлжээ хүлээн авагч төхөөрөмж /media converter/ цахилгааны хэлбэлзлээс үүдэн удаа дараа гэмтсэнийг А болон В талын хоёр талын төхөөрөмжийг шинээр байршуулж сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажилласан.

6. Мөн хэлтсийн байранд ашиглагдаж байгаа дотоод сүлжээний “SOPHOS” загварын роутер ачааллын улмаас удаа дараа саатахад хөдөлгөөнт роутер болох 4G төхөөрөмжийг холбон иргэдэд чирэгдэл учруулалгүй хэвийн ажиллагаанд оруулж ажиллажээ.



Сумдын улсын бүртгэгч нарын ашиглаж буй тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа алдагдаж байнгын эвдрэл гэмтэл гарч, мөн урсгал засварын хугацаа алдагдаж засварлагдахгүй болох зэрэг тохиолдлууд гарч дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд:

✓ Сайхан сумын албан хэрэгцээнд ашиглагдаж буй samsung 1660 загварын принтер ажиллахгүй HP LaserJet 135a маркийн 3 үйлдэлд принтерийг шинээр сольсон.

✓ Сайхан, Баянгол, Мандал сумын улсын бүртгэгчид /3/ Хяналтын улсын байцаагч, Хуулийн этгээд, Эд хөрөнгийн 3 бүртгэгч, Бичиг хэргийн ажилтанд тус бүр Canon DS-70000 маркийн 3 үйлдэлт сканерыг шинээр тус тус суурилуулав.

✓ Баянгол, Хүдэр, Алтанбулаг, Сайхан сумын улсын бүртгэгч нарын принтерийн засвар үйлчилгээ, принтерийн хор, сканерыг засварлалаа.

ЕС. ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, ХУУЛЬ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

Мэдээллийн ил тод байдлыг иргэд олон нийтэд нээлттэй байлгах, зохион байгуулагдсан арга хэмжээ, сургалт семинарын мэдээ мэдээллийг цаг тухай бүр хэлтсийн цахим хуудас www.selenge.burtgel.gov.mn нүүр ном хуудас буюу /facebook page/ болох Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нийтлэн ажиллажээ.

Цахим хөгжлийн яамнаас төрийн байгууллагуудын web хаяг Gov.mn цахим хуудас шинэчилж, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia-д нэгтгэгдсэн. Тус хэлтсийн <https://e-mongolia.mn/org/selenge-burtgel> вебийг бүрэн хөгжүүлэлт хийж дуусгалаа.

Хэлтсийн цахим хуудас болон нүүр ном хуудсанд нийт 58 мэдээ байршуулсан байна. Үүнд:

- Иргэдэд мэдээлэл зар хүргэх -15
- Байгууллагын хийгдсэн ажлын талаар -10
- Бусад байгууллагын гаргасан мэдээг түгээх -33

Улсын бүртгэлийн ерөнхий газрын “Албан хаагчийн гүйцэтгэлийн тайлан, үнэлгээг ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах тухай” удирдамжийн дагуу “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас-gov.mn” 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн тайланг байршуулан ажиллалаа.

Мэдээллийн ил тод байдал ханган ажиллаж shilen.gov.mn хаягт 3-р улирлын мэдээллээ байршуулан 87,3 хувьтайгаар баталгаажсан төлөвтэй байна.

#	Тайлант үе	Хувилбар	Төлөв	Төлөвийн огноо	Илгээсэн хэрэглэгч	Баталгаажсан үнэлгээний хувь	Баталсан мэргэжилтэн	Үйлдэл
1	2025 оны 3 улирал	1	Баталгаажсан	2025-10-29	selenge@burtgel.gov.mn	87.33%	Н.СҮВД-ЭРДЭНЭ	

Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 16 жилийн ой, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр” –ийг угтан Монгол улсын төрийн далбаа, Сэлэнгэ аймгийн бэлэг тэмдэг бүхий туг, Сэлэнгэ аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн тугийг тус тус 85 хоногийн хугацаатай мандууллаа.




Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85, бүртгэлийн нэгдсэн тогтолцоонд шилжсэний 16 жилийн ой, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр” –ийг угтан хэлтсийн нийт албан хаагчид утасны дуудлагадаа бүртгэлийн байгууллагын “Гэгээн үйлсийн эзэд” сүлд дууг / Код:131643/,

Skymelody /Код:120115/, Unimusic /Код:1131643/ утсандаа 85 өдөр эгшиглүүлэхээр тохирууллаа.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын Удирдах ажилтны зөвлөгөөн болон Сэлэнгэ аймгийн удирдах ажилтны 2025 оны зөвлөгөөнд хэлтсийн дарга Б.Саранчимэг тус тус оролцов.



Төрийн албаны зөвлөлөөс “7.4.10” сургалтыг 2025 онд / ZOOM/ -ээр хийж хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдсан. Үүнд:

- Эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал
- Төрийн албан хаагчийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгийн танилцуулга


- Хяналт шалгалтын хүрээнд илэрч байгаа зөрчил, дутагдал, эрсдэл, анхаарах асуудал
- Хяналт шинжилгээ үнэлгээ хийх
- Хүний эрхийн боловсрол
- Монгол юникодын асуудал




МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН
АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

“7:4:10” вэбинар сургалт

Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлал Дархан-Уул аймаг /Төвийн бүсийн сургалт/



Сэлэнгэ аймгийн засаг даргын тамгын газраас 2025 оны 03 дугаар сарын 21-ны өдөр “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн хэлэлцүүлэгт хэлтсийн албан хаагчид оролцлоо.



Авлигатай тэмцэх газраас 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр “ Авлигын ойлголт”, “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “ Авлигын гэмт хэрэг” сэдвээр Сэлэнгэ аймагт сургалт зохион байгуулсан бөгөөд хэлтсийн дарга Б.Саранчимэг оролцож судалгаанд хамрагдлаа.

АВЛИГЫН ЭСРЭГ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын зорилго: Сэлэнгэ аймаг, Орхон аймаг, Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын нийт албан тушаалтанд авлигын эсрэг сургалтыг цахимгаар зохион байгуулах.

Сургалт зохион байгуулах огноо: 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 14 цаг 00 минут.

Хугацаа	Сэдэв	Мэдээлэл хийх албан хаагч
14:00-14:10	Сургалтын нээлтийн үг.	УССГХ-ийн ахлах ажилтан, өмчлөх комиссар Б.Төрбаян
14:10-14:40	Авлигын ойлголт.	УССГХ-ийн ажилтан Э.Хүснэн
14:40-15:10	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь.	УССГХ-ийн ажилтан, комиссар С.Баярцэцэг
15:10-15:40	Авлигын гэмт хэрэг.	УССГХ-ийн ажилтан А.Тунэмал-Эрдэнэ
15:40-15:50	Сургалтад оролцогчдоос судалгаа авах.	УССГХ-ийн ажилтан А.Тунэмал-Эрдэнэ

<https://us06web.zoom.us/j/82025554170?pwd=b8mpvuuQhGQ5KqkxzeBPaNvctOnTH.1>

pass110

Хүндэтгэсэн,

БАЯРТСЕТСЭГ Soyolsaikhan



БНСУ-ын Кангвон дахь “IUTC” олон улсын сургалтын төвөөс 2025 оны 02 дугаар сарын 16-наас 22-ны өдрүүдэд зохион байгуулсан Сэлэнгэ аймгийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах богино хугацааны сургалтад тус хэлтсийн нярав ажилтай Я.Отгонзаяа хамрагдаж амжилттай оролцлоо.



Онцгой байдлын ерөнхий газрын дарга хошууч генерал Г.Ариунбуян команд штабын сургалт



Сэлэнгэ аймагт ойт хээрийн бүс нутагт онц их хэмжээний ой хээрийн түймэр гарч хандивын аянд хэлтсээрээ нэгдэж, сумдын улсын бүртгэгч нар түймэр унтааж байгаа албан хаагч, иргэдийн хоол, хүнс хийхэд дайчлагдан ажиллаж байгаа нь






Ерөө сумын Улсын бүртгэгч С.Солонго бүртгэлийн 85 жилийн ойн хүрээнд бүртгэлийн үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаа.



Ерөө сумын ИТХурлын даргын 2025 оны А/27 дугаартай “Хяналт шалгалт зохион байгуулах тухай” захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт нарийн бичгийн даргаар улсын бүртгэгч С.Солонго ажиллаж Ерөө суманд үйл ажиллагаа явуулж буй 3 сүм хийдийн нөхцөл байдалтай танилцан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс ирүүлсэн судалгааг асуумжийн дагуу бөглүүлэн, тайланг мэдээллэн ажиллалаа.



Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 3 удаагийн Төрийн албаны ерөнхий шалгалтад тус хэлтсийн улсын бүртгэгч бүртгүүлсэн иргэдийн биеийн давхцахгүй өгөгдлийн мэдээлийг шалгаж хамтран ажиллалаа.



Онцгой байдлын газартай хамтран “Ойн түймэр”, “Дуут дохион сургалт”-д оролцов.




Монголын хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “ПРО-БОНО” өдөрлөгийг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдөр Сэлэнгэ аймгийн Олон улс худалдааны төвийн талбайд зохион байгуулсан бөгөөд хэлтсийн албан хаагчид иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч оролцов.

Улсын бүртгэлийн Ерөнхий газраас “Мэдээлэл технологийн албан хаагч нарт мэдлэг олгох сургалт”-ыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ноос 18-ны өдрүүдэд зохион байгуулсан мэдээллийн технологийн ажилтан хамрагдсан болно.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газраас 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдөр Салбарын өнөөгийн байдал дэвшилтэт технологи инновац нэвтрүүлэх мэдээллийн технологийн хүний нөөцийн хөгжлийн талаарх “Tech week 2025” арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд Хэлтсийн дарга Б.Саранчимэг, улсын бүртгэгч Э.Зол-Эрдэнэ, Мэдээлэл технологийн ажилтан Г.Номин нар оролцлоо.



Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Цахим хөгжил, инновац, харилцааны холбооны яам, Сэлэнгэ аймгийн Засаг даргын тамгын газраас 2025 оны 09 дүгээр сарын 15-ний өдөр 14:00 цагаас онлайнаар “zoom” Улсын хэмжээнд аймаг, нийслэл, сум, тосгодоод албан ёсны “Төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас-gov.mn”-ийн хөгжүүлэлтийг шинээр хийж ашиглалтад оруулсан тухай уг цахим хуудасны талаарх сургалтад хамрагдлаа.



Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн 4/10776 дугаартай “Сумдын улсын бүртгэгч нарыг дадлагажуулах” албан бичгээр ирүүлсэн сургалтыг 10 дугаар сарын 02, 22-ны өдрүүдэд зохион байгуулсан бөгөөд /ZOOM/-зохион байгуулсан бөгөөд 17 сум 5 тосгоны улсын бүртгэгч нар хамрагдлаа.


Тагнуулын ерөнхий газраас төвийн бүсийн аймгуудад 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр “Кибер аюулгүй байдал” сэдвээр сургалтыг зохион байгуулсан бөгөөд Хэлтсийн дарга Б.Саранчимэг, Мэдээлэл технологийн ажилтан Г.Номин нар оролцлоо.



Сэлэнгэ аймгийн цагдаагийн газрын хүүхдийн байцаагч ахмад Ө.Болор 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хэлтсийн албан хаагчдад сургалтын танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт /ZOOM/ цахимаар “Гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг” сэдвээр сургалт хийж Сэлэнгэ аймгийн хэмжээнд эрх зөрчигдсөн гэр бүл, хүүхдийн тоон судалгаа танилцууллаа.



Хэлтсийн дарга Б.Саранчимэг 2025 оны 10 дугаар сарын 21-ны өдөр “Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим”, “Бидний ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм” сэдвүүдээр, 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдөр “Ёс зүйн зорилго, үндсэн асуудал”, “Ёс зүйн судлах асуудал, үүрэг ач холбогдол” сэдвүүдээр тус тус сургалт зохион байгууллаа. Сургалтыг хэлтсийн сургалтын танхимаас болон цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд хэлтсийн албан хаагчдад танхимаар, сумдын улсын бүртгэгч нарт цахим /ZOOM/-ээр бүрэн хамрагдлаа.



ТАЙЛАН ГАРГАСАН:СЭЛЭНГЭ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.САРАНЧИМЭГ